



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/119

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар “Ховд сити такси” ХХК-ийн барьж гүйцэтгэсэн “Үйлчилгээтэй 16 айлын орон сууц”-ны барилга угсралтын ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

- Комиссын дарга: З.Өмиртай - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга
- Гишүүд: Д.Нямтулга - Мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч
- Б. Эрдэнэцэцэг - Мэргэжлийн хяналтын газрын эрүүл ахуйн халдвар хамгаалалын хяналтын улсын байцаагч
- Г.Ганжаргал - Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцаагч
- С.Өнөржаргал - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн
- Р. Цэцэгмаа - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын хэлтсийн ахлах мэргэжилтэн
- М.Нансалмаа - Нийтийн аж ахуйн “Шим-Ус” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер
- Н.Ням-Эрдэнэ - “Ховд цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ийн ерөнхий инженер

.. 8400 07 0628

- Т.Бямбатөмөр - “Ховд дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн ерөнхий инженер
- Б.Сүхбаатар - Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны Ховд аймаг дахь зөвлөлийн тэргүүн
- Д.Алтанхуяг - “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн ерөнхий инженер
- Б.Бямбасүрэн - Зураг төслийн “Алтайн газрын хүч” ХХК-ийн захирал
- Б. Отгонтулга - “Ховд сити такси” ХХК-ийн захирал
- С.Батдорж - Аймгийн Архивийн тасгийн дарга

Нарийн бичгийн

дарга: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Орон сууцны зориулалттай барилга угсралтын ажлыг зураг, төслийн дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг комиссын дарга (З.Өмиртай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т. ЖАРГАЛСАЙХАН